


НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ХЭМЖЭЭНД
2018 ОНД АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛГООР ХЭРЭГЖҮҮЛСЭН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН.

2019.01.14

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө, газрын тухайн оны авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд төлөвлөсөн ажлуудыг үр дүнтэй хийж гүйцэтгэн ажиллалаа. Үүнд:

1. Манай байгууллага нь үндсэн 6 зорилт, 11 арга хэмжээ бүхий “Нийтлэг үйлчилгээний газрын хэмжээнд 2018 онд хэрэгжүүлэх авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө” гаргаж батлуулсан бөгөөд уг төлөвлөгөөг байгууллагын хэмжээнд мөрдөн ажиллаж, төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх тайлан мэдээг улирал бүр бэлтгэн эрх бүхий байгууллагад илгээж ажилласан. Мөн авилгын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан, энэ чиглэлийн мэдээ мэдээллийг байгууллагын цахим сайт болон мэдээллийн самбарт тогтмол байршуулан, газрын ажилтан, албан хаагчдад 5 удаагийн мэдээллийн цагаар авилгын эсрэг хууль тогтоомж, хариуцлага, сахилга бат, ёс зүй, шинээр мөрдөгдөж буй хууль, дүрэм, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай сургалт мэдээллийг мэргэжлийн байгууллага, төлөөллөөр өгүүлэн сурталчилан ажилласан болно.



Зураг . МУБИС-ийн багш, докторант О.Мягмарын
“Харицааны зиндаа” сэдэвт сургалт

2. Хүний нөөцийн ил тод байдлыг ханган нээлттэй ажлын байрны мэдээлэл, холбогдох утасны дугаар, хаягийн мэдээллийг Нийтлэг үйлчилгээний газрын www.khangardi.mn цахим систем болон байгууллагын ил тод байдлын самбарт тогтмол байршуулан нийтэд мэдээлж буй болно. Мөн сул орон тоо, нээлттэй ажлын байрны мэдээллийг зарын нэгдсэн сайт www.unegui.mn-д байршуулахын зэрэгцээ дүүргүүдийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний

хэлтэст захиалга өгч байна. Тайлант хугацаанд нийт 27 удаагийн зараар 136 хүн материалаа ирүүлж нөөцөд бүртгэгдсэн ба анкет, хувийн хэргээс сонгон шалгаруулалт хийж ажлаас чөлөөлөгдсөн, жирэмсний амралттай, захиргааны чөлөөтэй, тэтгэвэрт гарсан ажилтнуудын оронд 81 хүнийг шинээр ажилд авч ажиллуулж байна. Түүнчлэн НҮГ-аас зохион байгуулсан “Таныг сонсьё” аяны хүрээнд сул орон тоо ажлын байрны зарыг иргэд, олон нийтэд нээлттэй хүргэн ажилласан. Хүний нөөцтэй холбоотой тушаал шийдвэрийн төслийг хууль эрх зүйн стандартын төвшинд боловсруулах хүрээнд тайлант хугацаанд тус газрын хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод журам, ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтыг шинэчилэн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.




3. Шинээр албан тушаалд нэр дэвших 10 хүний ХАСУМ-ийг АТГ-т хүргүүлж тус газраас ирүүлсэн хариуг үндэслэн газрын даргын шийдвэрийг үндэслэн 8 хүнийг шинээр ажилд томилон ажиллуулж байна. Тайлант хугацаанд ХАСХОМ-ын гаргаж баталгаажуулсан 11 ажилтан, шинээр томилогдсон 8, нийт 19 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалдах ажлыг ЭБАТ холбогдох журмын дагуу зохион байгуулан ажиллалаа.
4. Нийт ажилтан, албан хаагчдад шударга ёс, ёс зүй, сахилга хариуцлагыг талаар мэдлэг, мэдээлэл олгох зорилгоор байгууллагын мэдээллийн цагаар НЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Ууганжаргал “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр, Улсын мөрдөн байцаах газрын мөрдөх албаны дүн шинжилгээ хяналт хариуцсан ахлах мөрдөн байцаагч дэд хурандаа Э.Нэмэхжаргал “Хариуцлага, сахилга бат, ёс зүй” сэдвээр, НЗДТГ-ын ТЗУХ-ийн Төрийн албан хаагчдын ёс зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн Т.Бат-Оргил “Төрийн албан хаагчийн харилцаа, хандлага” сэдвээр тус тус мэдээлэл хийсэн. Дээрх сургалтуудад НҮГ-ын Захиргаа, санхүүгийн хэлтэс, Байр ашиглалтын алба, Үйлчилгээний албаны 250 гаруй ажилтан, албан хаагч хамрагдсан болно.





Зураг. Байгууллагын мэдээллийн цагаар авсан харилцаа, хандлага ёс зүйн сургалтын явцаас

5. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан төрийн албан хаагчдыг авлига, ашиг сонирхол, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалтад манай байгууллагын 46 албан хаагч хамрагдсан болно. Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, шударга, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх талаар үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, албан тушаалтантай хамтарч ажиллах, үйл ажиллагааг нь дэмжих, харилцан уялдаатай ажиллаж ирлээ.



6. Авилгатай тэмцэх газраас ирсэн зөвлөмж шийдвэрийг дагаж мөрдөн, авилгын эсрэг хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж, мэдээ тайланг улирал бүр эрх бүхий байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. Бид авилгатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжтэй танилцаж, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллаж буй бөгөөд

өнөөдрийн байдлаар 1 албан хаагчийн талаар гомдол ирснийг судалж, холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, ажлаас чөлөөлсөн. Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн нээлттэй хэлбэрээр зохион байгуулж, тайланг сар бүрийн 01-ний өдрийн дотор Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн ажиллаж байна.

Дүгнэлт

Нийтлэг үйлчилгээний газрын хэмжээнд Монгол Улсын Их хурал болон Засгийн газар, Нийслэлийн Засаг дарга түүний Тамгын газраас баритмалж буй бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн 2018 онд Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг ханган ажилласнаар ажилтан, албан хаагч бүрт авлигын нийгэмд учруулах хор хөнөөл, сөрөг үр дагаврын талаар тодорхой хэмжээний мэдлэг олгож, эерэг, зөв хандлага бүхий иргэн, албан тушаалтныг төлөвшүүлж буй ололттой талтай болно.

Тайлантай танилцсан:


Захиргаа, сүүгийн хэлтсийн дарга



Ч.Шинэчимэг

Тайлан бичсэн:

Хууль эрх зүй, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ажилтан



Э.Хоролдулам

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

(2018 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл
1.	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).	<ul style="list-style-type: none"> - Төсөл хөтөлбөрийн нэр: “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” - Огноо, шийдвэрийн дугаар: Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоол - Төсөл, хөтөлбөрийн зорилго: Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Байхгүй
3.	Хэрэгжүүлэгч байгууллага /хэрэгжих нийт хугацаа /	ННҮГ
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт 1 Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан ажиллах, энэ талаарх мэдээллийг иргэд байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах</p> <p>Зорилт 2 Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах</p> <p>Зорилт 3 Хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах, мэдээлэх, хяналт тавих ажлыг хуулийн дагуу зохион байгуулах</p> <p>Зорилт 4 Албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх</p> <p>Зорилт 5 Авлигын эсрэг нийслэлээс явуулж буй бодлого, шийдвэрийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээ мэдээллийг иргэн, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэх</p> <p>Зорилт 6 АТГ-аас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, тайлагнах</p>

5.	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	Байхгүй					
		Үүнд:	Төсөв (он)		Гүйцэтгэл		Хувь	
		Багц 1						
		Багц 2						
Төсөл, хөтөлбөрийн зорилт:		<i>Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.</i>						
6.	1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн:	<p>1-р зорилтын хүрээнд Манай байгууллага нь үндсэн 6 зорилт, 11 арга хэмжээ бүхий "Нийтлэг үйлчилгээний газрын хэмжээнд 2018 онд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө" гаргаж батлуулсан бөгөөд уг төлөвлөгөөг байгууллагын хэмжээнд мөрдөн ажиллаж, төлөвлөгөний хэрэгжилтийн талаарх тайлан мэдээг улирал бүр бэлтгэн эрх бүхий байгууллагад илгээж байна. Мөн авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан, энэ чиглэлийн мэдээ мэдээллийг байгууллагын цахим сайт болон мэдээллийн самбарт тогтмол байршуулан, газрын ажилтан, албан хаагчдад авилгын эсрэг хууль тогтоомжийг сурталчилан ажиллаж буй болно.</p> <p>Хүрэх үр дүн: Энэхүү зорилт нь ажилтан, албан хаагч бүрт авлигын сөрөг нөлөө, үр дагаврын талаар мэдлэг, мэдээлэл олгож, авлигыг жигших, авлигаас ангид байх ухамсрыг төлөвшүүлэхэд оршино.</p>						
	2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн : Санамж: Хүрэх гол үр дүнг бичнэ.	<p>2-р зорилтын хүрээнд Нээлттэй ажлын байрны мэдээлэл, холбогдох утасны дугаар, хаягийн мэдээллийг Нийтлэг үйлчилгээний газрын www.khangardi.mn цахим систем болон байгууллагын ил тод байдлын самбарт тогтмол байршуулан нийтэд мэдээлж буй болно. Мөн нээлттэй ажлын байрны мэдээллийг зарын нэгдсэн сайт www.unegui.mn-д байршуулахын зэрэгцээ дүүргүүдийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст захиалга өгч байна. Түүнчлэн НҮГ-аас зохион байгуулсан "Таныг сонсьё" аяны хүрээнд сул ажлын байрны зарыг иргэд, олон нийтэд нээлттэй хүргэсэн.</p> <p>Хүрэх үр дүн: Нээлттэй ажлын байрны мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсээр дамжуулан нийтэд</p>						


	<p>хүртээмжтэй байдлаар хүргэснээр сул ажлын байр сонирхсон хандалт ихсэх, үүнээс чадамжтай ажилтан, албан хаагчдыг сонгох, ажлын байрны сонгон шалгаруулалтыг нийтэд ил тод, шударга байдлаар зохион байгуулах боломж бүрдэнэ. Үүний үр дүнд хүний нөөцийн бүрдүүлэлтийн ил тод байдал бүрэн хангагдана.</p>
<p>3-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн:</p>	<p>3-р зорилтын хүрээнд Шинээр удирдах албан тушаал болон хөрөнгө итгэмжлэн хариуцах албан тушаалд томилогдсон нийт 8 ажилтны ХАСУМ-ийг гаргаж, АТГ-т хүргүүлсэн бөгөөд тус газраас ирүүлсэн хариуг үндэслэн, албан хаагчид ажил үүргээ гүйцэтгэж байна.</p> <p>2019 оны ХАСХОМ-ын мэдүүлэг өгөх 19 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгадал ажлыг ЭБАТ холбогдох журмын дагуу зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Хүрэх үр дүн: Шинээр албан тушаалд томилогдохоор нэр дэвшиж буй албан хаагч бүрийн ХАСУМ-ийг гаргаж, АТГ-т хүргүүлэн тус газраас ирүүлсэн зөвлөмжийг үндэслэн томилгоог хийх, ХАСХОМ гаргах үүрэг бүхий албан тушаалтны мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, бүрэн гаргаж баталгаажуулах, хувийн ашиг сонирхлын зөрчилтэй албан тушаалтанг эрх бүхий албан тушаалд ажиллуулахаас урьдчилан сэргийлэх.</p>
<p>4-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн:</p>	<p>4-р зорилтын хүрээнд Нийт ажилтан, албан хаагчдад шударга ёс, ёс зүй, сахилга хариуцлагыг талаар мэдлэг, мэдээлэл олгох зорилгоор байгууллагын мэдээллийн цагаар НЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Ууганжаргал "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдвээр, Улсын мөрдөн байцаах газрын мөрдөх албаны дүн шинжилгээ хяналт хариуцсан ахлах мөрдөн байцаагч дэд хурандаа Э.Нэмэхжаргал "Хариуцлага, сахилга бат, ёс зүй" сэдвээр, НЗДТГ-ын ТЗУХ-ийн Төрийн албан хаагчдын ёс зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн Т.Бат-Оргил "Төрийн албан хаагчийн харилцаа, хандлага" сэдвээр тус тус мэдээлэл хийсэн. Дээрх сургалтуудад НҮГ-ын Захиргаа, санхүүгийн хэлтэс, Байр ашиглалтын алба, Үйлчилгээний албаны 250</p>

		<p>гаруй ажилтан, албан хаагч хамрагдсан болно.</p> <p>Хүрэх үр дүн 1: Ажилтан, албан хаагч бүр төрийн албан хаагчийн ёс зүйг баримтлах, сахилга хариуцлагыг биелүүлэх, шударга байдлыг эрхэмлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх үзэл суртлыг нэвтрүүлэх.</p>
	<p>5-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн:</p>	<p>5-р зорилтын хүрээнд Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан төрийн албан хаагчдыг авлига, ашиг сонирхол, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалтад манай байгууллагын 46 албан хаагч хамрагдсан болно.</p> <p>Хүрэх үр дүн 1: Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, шударга, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх талаар үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, албан тушаалтантай хамтарч ажиллах, үйл ажиллагааг нь дэмжих, харилцан уялдаатай байх.</p>
	<p>6-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн:</p>	<p>6-р зорилтын хүрээнд Авилгатай тэмцэх газраас ирсэн зөвлөмж шийдвэрийг дагаж мөрдөн, авилгын эсрэг хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж, мэдээ тайланг улирал бүр эрх бүхий байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>Бид авилгатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжтэй танилцаж, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллаж буй бөгөөд өнөөдрийн байдлаар 1 албан хаагчийн талаар гомдол ирснийг судалж, холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, ажлаас чөлөөлсөн.</p> <p>Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн нээлттэй хэлбэрээр зохион байгуулж, тайланг сар бүрийн 01-ний өдрийн дотор Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>Хүрэх үр дүн 1: Авилгатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг сахин биелүүлж, албан тушаалтан нэг бүр авлига ангид байх зарчмыг баримталж хэвших.</p>
7.	<p>Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</p>	<p>“Нийтлэг үйлчилгээний газрын хэмжээнд 2018 онд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө” гаргаж, хэрэгжилтийг ханган ажилласнаар ажилтан, албан хаагч бүрт авлигын нийгэмд учруулах хор хөнөөл, сөрөг үр дагаврын талаар тодорхой хэмжээний мэдлэг олгож, зэрэг, зөв хандлага бүхий иргэн, албан тушаалтныг</p>

		төлөвшүүлж буй ололттой талтай болно.		
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ		Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан төрийн албан хаагчдыг авлига, ашиг сонирхол, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалтад давтагдсан тоогоор манай байгууллагын 46 албан хаагч хамрагдсан байна.	
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилтын хэрэгжилт
		100 %	6	100 %
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ		
		100 %		


Хянаж, танилцсан

Захиргаа, санхүүгийн
хэлтсийн дарга

 Ч.Шинэчимэг

Тайлан гаргасан

Хууль эрх зүй, тогтоол шийдвэрийн
хэрэгжилт хариуцсан ажилтан

 Э.Хоролдулам